



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 6/09

Баян-Овоо

Р.Ринчинноровыг жолоочоор түр томилох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэхь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэхь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгон шалгаруулалтын оноогоор 43 оноо авсан Ринчиндоржийн Ринчинноровыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс жолоочоор туршилтын хугацаагаар түр томилсугай.

2. Р.Ринчинноровын ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Дарга: Д.Агаармандал (Санхүү албаны дарга)
Гишүүд: Э.Өлзийсайхан (Сангийн нягтлан бодогч)
Д.Гэрэлтуяа (Нярав)

3. Р.Ринчинноровын үндсэн цалинг TY-3 ангиллаар тооцон 1,052,000 (Нэг сая тавин хоёр мянга) төгрөгөөр тогтоон, төрийн алба хаасан хугацааны 8 (найм) нэмэгдэл, орон нутгийн 60 (жар) хувийн нэмэгдлийг тус тус олгохыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-д даалгасугай.

4. Р.Ринчинноровт ажилдаа хурдан дадлагажиж, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд мөрдөн, хариуцсан эд зүйлсээ ариг гамтай сайн ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ГЭРЭЛМАА



020000101